

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/43/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a> Ахлах аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:bayarmaao@audit.gov.mn">bayarmaao@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.1. ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин .....	9
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4.5.1 Завсрын аудитын талаар.....	10
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
5.1 Албан шаардлага .....	12



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ КУВЕЙТИЙН БАЙГАЛЬ  
ХАМГААЛАХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ А.АЙБЕК ТАНАА

2026.03.16 № 06/643  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тус төвийн өмнөх онуудад болон тайлант онд үссэн цахилгааны болон нийгмийн даатгалын шимтгэл, татварын өрийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй 771.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Авлага дансны үлдэгдэлд 3-аас дээш жилийн насжилттай өмнө ажиллаж байсан 4 ажилтан, 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Байгууллагын шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглаж Богдхан уулын Дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 3.5 га газрын ашиглах эрхийн гэрчилгээ нь "Богдхан уулын Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны нэр дээр бүртгэлтэй" гэх боловч ашиглах хугацаа дууссан, сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6- заасантай тус тус нийцэхгүй бөгөөд Санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 828 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 99 нэрийн, нийт 5,108.1 сая төгрөгийн балансын үнэ, 748.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлсэн, 861 дүгээр тогтоолын дагуу 506 нэрийн, нийт 218.4 сая төгрөгийн балансын үнэ, 214.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлсэн Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо Богдхан уулын Дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 4,500.9 сая төгрөгийн анхны өртөгтэй судалгааны төв байр, харуулын байр, 12 айлын орон сууц нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй байна.

### **Бусад асуудал**

Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т нэгтгэж, Засгийн газрын 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 87 дугаар Кувейт улстай хэлэлцээр батлах тухай тогтоолоор баталсан “Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын санамж бичиг”-ийн дагуу тус төвийн зохион байгуулалтын бүтцэд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	159,727,080.26	5,858,825.63
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,446,795.52	1,812,750.73
1.1.2	Дансны авлага	4,046,074.90	4,046,074.90
1.1.6	Бараа материал	146,234,209.84	-
1.2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	4,586,117,549.54	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,585,548,049.54	-
1.2.2	Биет бус хөрөнгө	569,500.00	-
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,745,844,629.80</b>	<b>5,858,825.63</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	630,528,032.86	771,359,210.88
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	630,528,032.86	771,359,210.88
2.1.1.1	Дансны өглөг	294,535,012.99	379,318,228.10
2.1.1.2	Цалингийн өглөг	46,751,432.00	21,055,354.00
2.1.1.3	Татварын өр	212,203,318.16	251,458,713.51
2.1.1.4	НДШ - ийн өглөг	77,038,269.71	119,526,915.27
2.3	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	4,115,316,596.94	(765,500,385.25)
2.3.1	Өмч: - төрийн	7,880,761,400.00	7,880,761,400.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(1,943,234,895.40)	(1,943,234,895.40)
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,822,209,907.66)	(6,703,026,889.85)
2.3.9.11	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	(1,701,232,190.37)	(1,822,209,907.66)
2.3.9.10	Тайлант үеийн хур ашиг	(120,977,717.29)	(4,880,816,982.19)
2.4	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>4,745,844,629.80</b>	<b>5,858,825.63</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	789,995,320.69	503,210,662.40
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	789,995,320.69	503,210,662.40
5	Хүүгийн орлого	5,006.57	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	554,885,293.49	305,698,024.79
10	Ерөнхий ба удирдлагын зардал	233,081,628.27	565,040,055.07
11	Санхүүгийн зардал	500.66	111,367.23
12	Бусад зардал	112,429,994.82	35,772,360.84
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(4,477,405,836.66)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(110,402,096.55)	(4,880,816,982.18)
19	Орлогын татварын зардал	10,575,620.74	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(120,977,717.29)	(4,880,816,982.18)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(120,977,717.29)	(4,880,816,982.18)
24	Орлогын нийт дүн	789,995,320.69	503,210,662.40

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	405,436,276.28	468,744,242.21
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	371,031,269.71	444,815,973.00
	Бусад мөнгөн орлого	34,405,006.57	23,928,269.21
1.2	Мөнгөн зарлага (-)	399,132,068.65	476,834,747.19
	Ажиллагчдад төлсөн	114,719,449.00	213,956,415.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,000,000.00	-
	Бараа материал худалдан авахад төлсөн	152,017,274.00	118,501,701.00
	Ашиглалтын зардалд төлсөн	47,127,756.00	118,035,002.94
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,310,000.00	-
	Хүүгийн төлбөрт төлсөн	500.66	-
	Татварын байгууллагад төлсөн	9,076,291.98	-
	Бусад мөнгөн зарлага	71,880,797.01	26,341,628.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,304,207.63	(8,090,504.98)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	456,460.19
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	456,460.19
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	456,460.19
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,304,207.63	(7,634,044.79)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,142,587.89	9,446,795.52
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,446,795.52	1,812,750.73

### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,701,232,190.37)	4,236,294,314.23
3	Залруулсан үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,701,232,190.37)	4,236,294,314.23
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(120,977,717.29)	(120,977,717.29)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,822,209,907.66)	4,115,316,596.94
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
11	Залруулсан үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,822,209,907.66)	4,115,316,596.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(4,880,816,982.19)	(4,880,816,982.19)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(6,703,026,889.85)	(765,500,385.25)

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө		2024 он/2025 оны гүйцэтгэл	Харьцуулалт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Хувь	2025 оны төлөвлөгөө/ гүйцэтгэл	Хувь
<b>1</b>	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	<b>мян.төг</b>	<b>393,072.4</b>	<b>659,209.3</b>	<b>471,596.8</b>	78,524.4	120.0	187,612.5	71.5
<b>1.1</b>	<b>Үндсэн үйлдвэрлэл</b>	<b>мян.төг</b>	<b>353,394.2</b>	<b>624,209.3</b>	<b>452,627.6</b>	99,233.4	128.1	171,581.7	72.5
1.1.1	Хоол үйлдвэрлэл	мян.төг	-	155,209.3	-	-	-	155,209.3	-
1.1.2	Экологийн боловсрол олгох сургалт	мян.төг	353,394.2	469,000.0	452,627.6	99,233.4	128.1	16,372.4	96.5
<b>1.2</b>	<b>Үндсэн бус үйлдвэрлэл</b>	<b>мян.төг</b>	<b>39,678.2</b>	<b>35,000.0</b>	<b>18,969.2</b>	(20,709.0)	47.8	16,030.8	54.2
1.2.1	Бусад орлого	мян.төг	39,678.2	35,000.0	18,969.2	(20,709.0)	47.8	16,030.8	54.2
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>393,072.4</b>	<b>659,209.3</b>	<b>471,596.8</b>	78,524.4	120.0	187,612.5	71.5
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>783,561.8</b>	<b>661,933.9</b>	661,933.9	-	121,627.9	84.5
3.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	мян.төг	-	-	330,939.1	330,939.1	-	(330,939.1)	-
3.3	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	-	43,470.0	48,878.8	48,878.8	-	(5,408.8)	112.4
3.6	Үүнээс: Элэгдлийн зардал	мян.төг	-	-	282,116.0	282,116.0	-	(282,116.0)	-
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>мян.төг</b>	<b>393,072.4</b>	<b>(124,352.5)</b>	<b>(190,337.1)</b>	(583,409.5)	(48.4)	65,984.6	153.1
<b>5</b>	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>мян.төг</b>	<b>389,141.7</b>	<b>(123,109.0)</b>	<b>(188,433.7)</b>	(577,575.4)	(48.4)	65,324.7	153.1
<b>6</b>	<b>Төсвийн төлбөр</b>	<b>мян.төг</b>	<b>21,175.5</b>			(21,175.5)			
6.5	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	5,070.8			(5,070.8)			
6.6	ХХОАТ	мян.төг	16,104.7			(16,104.7)			
<b>7</b>	<b>Төрийн өмчийн ногдол ашиг</b>	<b>мян.төг</b>		-	-	-			
<b>8</b>	<b>Ажиллагсдын тоо</b>	<b>хүн</b>	<b>11</b>	<b>18</b>	<b>6</b>	(5)	54.5	12	33.3
<b>9</b>	<b>Нийт цалингийн сан</b>	<b>мян.төг</b>	<b>22,194.3</b>	<b>370,065.6</b>	<b>11,930.0</b>	(10,264.3)	53.8	358,135.6	3.2
<b>10</b>	<b>Нэг ажилтны сарын дундаж цалин</b>	<b>мян.төг</b>	<b>2,017.7</b>	<b>1,713.3</b>	<b>1,988.3</b>	(29.3)	98.5	(275.1)	116.1
<b>11</b>	<b>Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал</b>	<b>төгрөг</b>		<b>0.8</b>	<b>0.7</b>	0.7	-	0.1	84.7
<b>12</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>108,460.0</b>	<b>-</b>	-	-	108,460.0	-
<b>13</b>	<b>Нийт авлага</b>	<b>мян.төг</b>	<b>4,046.0</b>		<b>4,046.0</b>	-	100.0	(4,046.0)	-
13.1	Үүнээс: Найдваргүй авлага	мян.төг				-	-	-	-
<b>14</b>	<b>Нийт өглөг</b>	<b>мян.төг</b>	<b>630,528.0</b>	<b>259,000.0</b>	<b>771,359.2</b>	140,831.2	122.3	(512,359.2)	297.8
14.1	Үүнээс: Богино хугацаат өр төлбөрт	мян.төг	630,528.0	259,000.0	771,359.2	140,831.2	122.3	(512,359.2)	297.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгаль хамгаалах төв, түүний үйл ажиллагаа

Кувейтийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ-ыг экологийн судалгаа шинжилгээ хийх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, боловсрол олгох үндсэн үйл ажиллагааг явуулах зорилгоор 2007 онд байгуулсан байна.

“Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ нь байгаль орчныг хамгаалах, судалгаа шинжилгээ хийх, хоёр орны байгаль орчин, судалгаа шинжилгээний хамтын ажиллагаа, нэн ховор ургамал болон амьтдыг хамгаалах, үржүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

#### 3.2 Төвийн гадаад, дотоод орчин

“Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, үйл ажиллагааны онцлогт тохируулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,739.9 сая төгрөгөөр буюу 99.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.4	1.8	7.6
Авлага	4.0	4.0	-
Бараа материал	146.2	-	146.2
Үндсэн хөрөнгө	4,586.1	-	4,586.1
Нийт хөрөнгийн дүн	4,745.8	5.8	4,739.9
Өр төлбөр	630.5	771.3	(140.8)
Эзэмшигчдийн өмч	4,115.3	(765.5)	4,880.8
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,745.8	5.8	4,739.9

Эх сурвалж: Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.8 сая төгрөг болж өмнөх оноос 7.6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлсөнтэй холбоотой.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 861 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 506 нэрийн, нийт 3.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг, 4.7 сая төгрөгийн бараа материалыг тус тус акталж данснаас хассан байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 828 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 99 нэрийн, нийт 5,108.1 сая төгрөгийн балансын үнэ, 748.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг, 113.8 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.

Дээрх хөрөнгөөс 23 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, 30.0 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон байна.

Эзэмшигчдийн өмч данс 4,880.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Leader” программыг ашиглаж байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу тус компани нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 770 дугаар тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 659.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 783.6 сая төгрөгөөр, 123.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 452.6 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 19.0 сая төгрөг, нийт 471.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 662.0 сая төгрөгийн зардал гарган, 188.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 471.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 187.6 сая төгрөг буюу 71.5 хувиар тасарсан нь барилга болон эд хогшил, техник тоног төхөөрөмж хуучирч муудсантай холбоотой “Экологийн боловсрол олгох сургалт”-ын тоо буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 662.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 121.6 сая төгрөг буюу 84.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой төлөвлөсөн зарим хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, дараагийн шатны чанарын хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал сонгосон суурь үзүүлэлтээс 0.5 хувиар тооцож 4.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд компанийн зардлаар бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх зэрэг хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 1,166.6 сая төгрөгийн 169 мэдээллийг байршуулахаас 158 мэдээллийг хугацаанд нь, 287.0 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгадагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илрүүлсэн нийт 5,230.0 сая төгрөгийн алдааг залруулах 5 зөвлөмж өгснөөс 4,454.6 сая төгрөгийн 2 алдааг залруулсан байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Санхүүгийн тайланд хийсэн өмнөх аудитаар “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” ба зөрчил гаргасан буруутай албан тушаалтныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 193 дугаар тогтоолоор ажлаас чөлөөлсөн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авлага, өр төлбөрийг барагдуулах асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг дахин нягтлах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 775.4 сая төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрсэнд зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлөөс 775.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 770.9 сая төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

### 5.1 Албан шаардлага

#### 1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын өмнөх онуудад болон тайлант онд үссэн цахилгааны болон НДШ, татварын өрийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй 771.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

1. Цахилгааны төлбөрийн өмнөх оны үлдэгдэл 269.7 сая төгрөг, тайлант оны 109.6 сая төгрөг, нийт 379.3 сая төгрөгийн өр төлбөртэй;
2. НӨАТ-ын 186.6 сая төгрөг, ХХОАТ-ын 50.5 сая төгрөг, бусад татварын 14.4 сая төгрөг, нийт 251.5 сая төгрөгийн өр төлбөртэй;
3. НДШ-ийн 119.5 сая төгрөгийн өр төлбөртэй;
4. Тус байгууллагын 2024 онд ажиллаж байсан 5 ажилтны 8.7 сая төгрөг, 2025 онд ажилласан 6 ажилтны 12.3 сая төгрөг, нийт 21.0 сая төгрөгийн цалингийн өглөгтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн дансанд хуримтлагдсан өмнөх оны болон тайлант оны цахилгааны төлбөр, татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ажилтнуудын цалингийн өрийг төлж барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

#### 2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлага дансны үлдэгдэлд 3-аас дээш жилийн насжилттай өмнө ажиллаж байсан 4 ажилтан, 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

#### 3. Газар ашиглах гэрчилгээтэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тус төвийн шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглаж байгаа Богдхан уулын Дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 3.5 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээ нь "Богдхан уулын Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны нэр дээр бүртгэлтэй" гэх боловч ашиглах хугацаа дууссан, сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглах эрхтэй газрын ашиглах хугацааг сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус байгууллагын өмнөх онуудад болон тайлант онд үссэн цахилгааны болон НДШ, татварын өрийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй 771.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд: 1. Цахилгааны төлбөрийн өмнөх оны үлдэгдэл 269.7 сая төгрөг, тайлант оны 109.6 сая төгрөг, нийт 379.3 сая төгрөгийн өр төлбөртэй; 2. НӨАТ-ын 186.6 сая төгрөг, ХХОАТ-ын 50.5 сая төгрөг, бусад татварын 14.4 сая төгрөг, нийт 251.5 сая төгрөгийн өр төлбөртэй; 3. НДШ-ийн 119.5 сая төгрөгийн өр төлбөртэй; 4. Тус байгууллагын 2024 онд ажиллаж байсан 5 ажилтны 8.7 сая төгрөг, 2025 онд ажилласан 6 ажилтны 12.3 сая төгрөг, нийт 21.0 сая төгрөгийн цалингийн өглөгтэй байна.	1	771,359.2			1	771,359.2						
2	Авллага дансны үлдэгдэлд 3-аас дээш жилийн насжилттай өмнө ажиллаж байсан 4 ажилтан, 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	4,046.1			1	4,046.1						
3	Тус ТӨААТҮГ-ын барилга байгууламж байршиж буй шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглаж байгаа Богдхан уулын Дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 3.5 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээ нь "Богдхан уулын Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны нэр дээр бүртгэлтэй" гэх боловч ашиглах хугацаа дууссан, сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	1	-			1	-						
	Дүн	3	775,405.3			3	775,405.3						



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 580/АД160066

Улаанбаатар хот

САГ - 2026/43/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын өмнөх онуудад болон тайлант онд үүссэн цахилгааны болон нийгмийн даатгалын шимтгэлийн, татварын өрийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй, 771,359,211.00 /долоон зуун далан нэгэн сая гурван зуун тавин есөн мянга хоёр зуун арван нэгэн/ төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

1. Цахилгааны төлбөрийн нийт 379,318,228.00 /гурван зуун далан есөн сая гурван зуун арван найман мянга хоёр зуун хорин найман/ төгрөгийн өр төлбөр;
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар болон бусад татварын нийт 251,458,714.00 /хоёр зуун тавин нэгэн сая дөрвөн зуун тавин найман мянга долоон зуун арван дөрвөн/ төгрөгийн өр төлбөр;
3. Нийгмийн даатгалын шимтгэлийн 119,526,915.00 /нэг зуун арван есөн сая таван зуун хорин зургаан мянга есөн зуун арван таван/ төгрөгийн өр төлбөр;
4. Тус байгууллагын 2024 онд ажиллаж байсан 5 ажилтан, 2025 онд ажилласан 6 ажилтанд олгох нийт 21,055,354.00 төгрөгийн цалингийн өглөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх өмнөх оны болон тайлант оны цахилгааны төлбөр, татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ажилтнуудын цалингийн өрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын захирал /А.Айбек/, нягтлан бодогч /Ж.Жавзандулам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 581/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/43/НА - СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын авлага дансны үлдэгдэлд 3-аас дээш жилийн насжилттай өмнө ажиллаж байсан 4 ажилтан, 1 аж ахуйн нэгж байгууллагаас авах нийт 4,046,075.00 /дөрвөн сая дөчин зургаан мянга далан таван/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх олон жилийн насжилттай, авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын захирал /А.Айбек/, нягтлан бодогч /Ж.Жавзандулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 582/A0160066

Улаанбаатар хот

САГ - 2026/43/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус ТӨААТҮГ-ын барилга байгууламж байршиж буй шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглаж байгаа Богдхан уулын Дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 3.5 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээ нь "Богдхан уулын Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны нэр дээр бүртгэлтэй" гэх боловч ашиглах хугацаа дууссан, сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах, ашиглах эрхтэй 3.5 га газрын гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын захирал /А.Айбек/, нягтлан бодогч /Ж.Жавзандулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БАЯРМАА